

Бүгд Найрамдах Чех улсад хөдөлмөр эрхлэх – Ажил алдах

АЖЛААС ГАРАХ ӨРГӨДӨЛ - Хэрэв та ажлаасаа гарахыг хүсвэл ажил олгогчдоо бичгээр мэдэгдэх ёстой. Ажлаас гарах өргөдлийг ердийн үед 2 сарын өмнө мэдэгдэнэ. Мэдэгдсэн хугацаа нь дараа сарын эхний өдрөөс эхэлнэ.

Жишээ: Та 9-р сарын 5-нд ажлаас гарах өргөдлөө өгсөн бол мэдэгдсэн хугацаа нь 10-р сарын 1-нээс эхлэн 11-р сарын 30-нд дуусна.

Та хөдөлмөрийн харилцааг цуцлах талаараа ажил олгогчтой тохиролцож болно. Энэ тохиолдолд та хөдөлмөрийн харилцааг дуусгах гэрээ (Dohodu o ukončení pracovního poměru) бичих бөгөөд үүнд ажлаас гарах өдрийн огноог бичнэ.

АЖЛЫГ ХАЛАГДАХ - ажлаас халагдах нь ажил олгогч таныг хална гэсэн үг. Та янз бүрийн шалтгааны улмаас ажлаасаа халагдах боломжтой, жишээлбэл:

- Таны ажлын байр хаагдсан.
- Тухайн ажлын байранд тавигдах мэргэшлийн шаардлагыг хангахгүй.
- Та ажлын үүргээ удаа дараа зөрчсөн.
 - Ажил олгогч зөрчлийн талаар зэмлэх бичгээр мэдэгдэнэ. Хэрэв та энэхүү бичгийг 2 удаа хүлээж авч, залруулга хийхгүй бол ажлаас халах боломжтой. Энэ тохиолдолд та ажлаас халагдсаны тэтгэмж авах эрхгүй.

АНХААР ! ЁС СУРТАХУУНЫГ НОЦТОЙ ЗӨРЧСӨН ТОХИОЛДОЛД, ТА ШУУД ХАЛАГДАХ БОЛОМЖТОЙ. Жишээлбэл, та ажилдаа согтууруулах эсвэл мансууруулах бодис хэрэглэсэн үедээ ирэх.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛ – Хэрэв та ажил эрхэлдэг бол таны цалингаас эрүүл мэнд, нийгмийн даатгалыг суутгана. Танай ажил олгогч үүнийг төлөх үүрэгтэй.

! АНХААР ! ХЭРВЭЭ ТА БНЧУ-Д АЖИЛ ЭРХЭЛДЭГҮЙ БОЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ ТӨЛӨХ ЁСТОЙ!

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХЭЛТЭС ДАХЬ БҮРТГЭЛ – зөвхөн Чех улсад байнга оршин суух эрхтэй хүмүүс

- Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс (Úřad práce) нь тохирох ажилд зуучлах, мэргэшлийн сургалтад хамруулах, ажилгүйдлийн тэтгэмж олгох мөн давтан мэргэших сургалтын явцад дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлдэг.
- Та Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст оршин суугаа газрынхаа дагуу бүртгүүлэх ёстой. Хэрэв та тохиромжтой ажилд зуучлах хүсэлт гаргасан тохиолдолд, та ажил хайгч болж, ажил хайгчдын бүртгэлд хамрагдана.

Илүү их мэдээллийг дараах цахим хуудаснаас авна уу www.uradprace.cz.

ХЭРВЭЭ ТА НӨХЦӨЛ БАЙДАЛДАА ИТГЭЛГҮЙ БАЙВАЛ ГАДААД ИРГЭДЭД ТУСЛАХ ТӨВӨӨС ЗӨВЛӨГӨӨ АВАХ НЬ ДЭЭР, БИД ТАНД ТУСЛАХДАА БАЯРТАЙ БАЙХ БОЛНО. УУЛЗАЛТЫН ЦАГАА УРЬДЧИЛАН ТОВЛООРОЙ.



FINANCOVÁNO
EVROPSKOU UNÍ
AZYLOVÝ, MIGRAČNÍ
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.